



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар A/198

Булган сум

Г Химийн бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн байгууллагуудын химийн лабораторид ашиглагдаж байсан устгах шаардлагатай химийн бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах 20,000,000 (хорин сая) төгрөгийн эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлاغнахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн байгууллагуудын химийн лабораторид ашиглагдаж байсан устгах шаардлагатай химийн бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

4. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д даалгасугай.



Sugar Ajil 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

F324010277